



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 1/121

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны "Сумын 2021 оны төсөв батлах тухай" 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын 2021 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх "Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны халаалтын шугамыг шинэчлэх /подволд халаалтын шугамыг хэсэгчлэн сольж узель хийх/ гадна шугамыг засварлах" ажилд зарцуулагдах 69137002 (жаран есөн сая нэг зуун гучин долоон мянга хоёр) төгрөгийг зарцуулсугай.

2. "Орон сууцны 3, 6, 7, 8-р байрны халаалтын шугамыг шинэчлэх /подволд халаалтын шугамыг хэсэгчлэн сольж узель хийх/ гадна шугамыг засварлах" ажилд зарцуулагдах 69137002 (жаран есөн сая нэг зуун гучин долоон мянга хоёр) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг нягтлан бодогч (О.Дөлгөөн)-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ